



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 25 өдөр

Дугаар

A/284

Хэрлэн сум

“Домогт хаадын бүжиг” бүжгийн спортын
холбоонд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.3 Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Домогт хаадын бүжиг” бүжгийн спортын холбоо нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу “Илүүдэл жингүй Эртэч Монгол” аяны хүрээнд зохион байгуулагдаж байгаа цэнгээнт бүжгийн тэмцээний зардалд 4.500.000 (дөрвөн сая таван зуун мянган) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн байгууллага, иргэдээс тавьсан санал хүсэлтийг шийдвэрлэх зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ